

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН
2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2014 оны 03 дугаар сарын 10-ны өдөр.

Тус Хяналтын зөвлөл нь “Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2006 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2 дахь хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг шүүхийн өмнөх шатанд урьдчилан хянах, тус хорооны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавих үндсэн үүрэгтэй орон тооны бус байгууллага юм.

Одоогийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн Улсын Их Хурлын 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 72 дугаар тогтоолоор томилогдсон бөгөөд даргаар Р.Ринчинбазар, гишүүдээр Ж.Эрдэнэбилэг, А.Өнөржаргал, Б.Амарсанаа, Д.Цэрэнбадам нар ажиллаж байна.

Дээрх хууль, журамд зааснаар Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй хуралдах, хуралдааны товыг Хяналтын зөвлөлийн дарга тогтоохоор журамлагдсан байдаг. Хяналтын зөвлөл шинээр байгуулагдаад 2014 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж (УИХ-тай харилцах, Санхүүгийн зохицуулах хороотой харилцах, Иргэд болон аж ахуйн нэгжийн гомдлыг хянах, Дотоод ажил, зохион байгуулалтын зэрэг асуудлыг тусгасан), хамгийн эхэнд эрх зүйн байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд баримтлах журмын талаар санал боловсруулах ажлын хүрээнд зөвлөлийн хуралдааны дэгийг шинээр боловсруулан баталсан.

Тус зөвлөл 2014 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлын талаар

Тайлангийн жилд Хяналтын зөвлөлд иргэд байгууллагаас 8 гомдол, 20 өргөдөл, санал хүсэлт ирүүлсэн бөгөөд заримд нь ажил хэргийн шугамаар хариу өгч үнэт цаасны холбогдолтой асуудлуудыг нь хуралдаанаар хэлэлцэж нь шийдвэрлэсэн болно.

“Анод банк” ХК-ийн “Хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хороо”-ны тэргүүн Т.Жигмэддагва нь Хяналтын зөвлөлд хандан “Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 100 дугаар тогтоол, 2008 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 122 дугаар тогтоол, мөн оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 124 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болгуулах” тухай 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр гомдол гаргасныг 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авч энэхүү гомдлыг хэлэлцэн Санхүүгийн зохицуулах хорооны Эрх

зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 32 дугаар хэсэг, “Санхүүгийн Зохицуулах Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын хүрээнд Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг баримтлан хуулинд заасан гомдол гаргах хугацаа дууссан тул хэргийг урьдчилан шийдвэрлэх үндэслэлгүй байгааг дурьдаад “ Гомдлыг хэрэгсэхгүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх” тогтоол гаргаж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах үүднээс холбогдох зөвлөгөөг өгч шийдвэрлэсэн болно. Үүний дараа “Анод банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигч хохирогчдын түр хорооноос Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заагдсан гомдол гаргах эрхээ шүүхээр сэргээлгэн тус Хяналтын зөвлөлд 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдөр 84 тоот албан бичгээр дээр дурьдсан 100, 122, 124 дүгээр тогтоолуудыг хүчингүй болгуулах тухай хүсэлтийг дахин гаргасан.

Энэхүү дахин гаргасан гомдлыг тус Хяналтын зөвлөл 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр авч хэлэлцээд, Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх 2013 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх маргаантай үйл баримтыг авч хэлэлцээд гэм буруутай этгээдийг тодорхойлсон, мөн уг тогтоолуудаас үүдэн гарсан хор хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлэх тухай эцэслэн шийдвэрлэснийг үндэслэн тогтоол хуулийн хүчин төгөлдөр хэвээр байгаа учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин нотлох шаардлагагүй” гэж заасан тул гомдлыг хүлээн авч шийдвэрлэх боломжгүйг дурдан гомдлыг хэрэгсэхгүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх тухай тогтоол гарч, хариуг албан тоотоор хүргүүлсэн болно.

Гэвч тус түр хорооны тэргүүн Т.Жигмэддагва нь 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Захиргааны хэргийн шүүхэд хандан гурван зүйл бүхий шаардлага хүргүүлсэн бөгөөд Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхээс нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүсгэсний дагуу холбогдох бүх тайлбарыг хяналтын зөвлөлөөс гаргаж өгсөн болно.

Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкнаас ирүүлсэн СЗХ-ны 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Нэр бүхий арилжааны банкуудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай” тогтоолтой холбогдох гомдлыг хүлээн авч шалгах, хорооноос тайлбар гаргуулах явцад СЗХ-ноос 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр тогтоол гаргаж, дээр дурьдсан 467 дугаар тогтоолыг хүчингүй болгож, арилжааны банкуудад “Үнэт цаасны зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг 2015 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүртэл сунгасан тул ирүүлсэн гомдолд дурьдсан асуудал шийдвэрлэгдсэнд тооцож хаасан болно.

Өөр нэгэн асуудал, тухайлбал Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос ирүүлсэн “СЗХ-ны Мэргэжлийн зөвлөлийн шийдвэртэй холбогдох гомдол”-д нэмэлт тайлбар, тодотгол гаргуулж авах шаардлагатай байгаа тул хурлаар хэлэлцэх хугацааг түр хойшлуулсан байгаа болно.

2. Хяналтын зөвлөлд ирсэн хүсэлт, албан тоот

Давж заалдах шатны 10 дугаар шүүхийн Тамгын газраас 2014 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 456 тоот албан бичиг, Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 18 дугаар тогтоол, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 1/703 тоот “Мэдэгдлийн хэрэгжилтийн тухай” албан бичиг, мөн хорооны 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1/810 тоот албан бичиг, 2014 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 3/1566 тоот албан бичиг, 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 5/1569 тоот албан бичиг, “Анод банк” ХХК-ны хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хорооноос 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 73 тоот албан бичиг, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчдын хэлтсээс ирүүлсэн бичиг 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн албан бичиг, Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхээс “Анод банк” ХК-тай холбоотой Улсын Дээд Шүүхийн тогтоол, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос СЗХ-ны Үнэт цаасны газрын даргатай холбоотой 2014 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 173 тоот албан бичиг, СЗХ-ноос 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 3/1231 тоот албан бичиг, мөн хорооноос “Хариу хүргүүлэх тухай”, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос “Өргөдлийн хариу”, СЗХ-ны Даатгалын газраас “Компаниудын төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлтүүд”, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгчийн захирамж, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн нэхэмжлэл, мөн шүүхийн мэдэгдэх хуудас, “Анод банк” ХХК-ны хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хорооны тэргүүн Т.Жигмэддагвын “Хүсэлт гаргах тухай”, итгэмжлэгдэгч Д.Бат-Эрдэнийн “СЗХ-ны дарга Д.Баярсайханд гомдол гаргах тухай”, “Зоос банк”-ны хувьцаа эзэмшигч Б.Цэрэнжаваас Хяналтын зөвлөлийн даргад “Хувьцаа эзэмшигчдийн хохирол барагдуулахад эрхийг сэргээж хангахад туслалцаа үзүүлэх тухай” албан бичгүүдийг хүлээн авч, бүртгэл хөтлөн Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулж, хурлаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн асуудлуудад тухай бүрт нь зохих хариуг өгч байсан болно.

3. Өргөдөл, гомдол хариу өгсөн талаар

Иргэн А.Эрдэнэсүвдэд гомдлын хариуг 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 тоот албан бичиг, иргэн Д.Эрдэнэцогтод гомдлын хариуг 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 07 тоот албан бичиг, иргэн Л.Цэвээнравданд гомдлын хариуг 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 08 тоот, 2014 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10 тоот албан бичиг, Монголын үнэт цаасны

арилжаа эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Ж.Цэдэнрагчаад шаардлагын хариуг 2014 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 11 тоот албан бичиг, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн гүйцэтгэх захирал Т.Гандуламд албан тоотын хариуг 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 15 тоот албан бичиг, “Анод банк” ХХК-ны хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хорооны тэргүүн Т.Жигмэддагвын өргөдөлтэй холбоотой Хяналтын зөвлөлийн хуралдааны 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 17 тоот тогтоол, мөн 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 03 тоот тогтоол гарсаныг албан бичгээр хүргүүлсэн.

4. Иргэд, байгууллагад явуулсан албан тоот

Нийслэлийн шүүхийн Тамгын газарт 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр 01 тоот, Хяналтын зөвлөлийн гишүүн, референтэд “Итгэмжлэл олгох тухай”, Хяналтын зөвлөлийн хуралдааны 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 03 тоот, СЗХ-ны дарга Д.Баярсайханд 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 тоот, Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхэд “Тайлбар хүргүүлэх тухай” 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 тоот, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхэд 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 тоот, СЗХ-нд 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 07, 08 тоот албан бичиг, СЗХ-ны дарга Д.Баярсайханд 2014 оны 02 дугаар сарын 18-ны 09 тоот, Шүүхийн Ерөнхий Зөвлөл 2014 оны 02 дугаар сарын 19-ний өдөр 12 тоот, СЗХ-ны дарга Д.Баярсайханд 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 13 тоот, СЗХ-ны Ажлын албаны дарга Х.Бум-Эрдэнэд 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 14 тоот, ҮЦТТХТ-ийн Гүйцэтгэх захирал Т.Гандуламд 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 15 тоот, Гадаад харилцааны сайд Л.Болдод 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 тоот, 05 дугаар сарын 09-ний өдөр 18 тоот, “Анод банк”-ны Хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хороо Т.Жигмэддагвад 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 17 тоот, СЗХ-ны дарга Д.Баярсайханд 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот, СЗХ-ны Даатгалын газрын дарга С.Ганболдод 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 19 тоот, “Анод банк” ХХК-ны хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хорооны тэргүүн Т.Жигмэддагвад өргөдлийн хариу, СЗХ-ны Ажлын албаны дарга Х.Бум-Эрдэнэд Хяналтын зөвлөлийн хуралдааны 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 03 тоот тогтоол, “Анод банк” ХХК-ны хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хорооны тэргүүн Т.Жигмэддагвад хурал хойшлуулах хүсэлтийн хувь, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхэд “Итгэмжлэл олгох тухай”, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхэд “Анод банк” ХХК-ны хувьцаа эзэмшигч, хохирогчдын түр хорооны тэргүүн Т.Жигмэддагвын нэхэмжлэлд хариу тайлбар өгөх, төн түүнд Хяналтын зөвлөлийн хуралдааны 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 03 тоот тогтоолын хувь, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхэд Т.Жигмэддагвад явуулсан тогтоолын хувь, хавсралт материал, Захиргааны

хэргийн анхан шатны 20 дугаар шүүхэд нотлох баримтуудыг хүргэсэн бөгөөд бусад албан бичгүүдийг явуулсан.

5. Бусад байгууллагатай харилцах талаар

Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж баталсан 2014 оны “Ажлын төлөвлөгөө”-ний дагуу Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг мэдээллэр хангах, тухайн чиглэлээр тулгамдаж буй асуудал, тэдгээрийг хэрэхэн шийдвэрлэж буй байдал, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хоорондын харилцаанд үүсч буй ололт, бэрхшээлийг судлах зорилгоор 9 удаагийн ажил хэргийн уулзалтыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Албан журмын даатгагчдын холбоо, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, Монголын даатгагчдын холбооны удирдлагуудтай ажил хэргийн уулзалт зохион байгуулж, тэдний тавьсан санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэх, хяналт зохицуулалтын үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгох талаар санал солилцож, эдгээр асуудлыг бодитой ажил хэрэг болгох үүднээс СЗХ өөрийн эрх мэдлийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх, дүрэм, журам батлан мөрдүүлэхэд бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр тус хорооны Бичил санхүүгийн газар, Даатгалын газар, Үнэт цаасны газрын удирлагуудтай санал солилцож, зохих зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлсэн болно.

Мөн Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, мэдээлэл, санал хүсэлтийг нь сонссон болно. Эдгээр үйл ажиллагааны чиглэлээр Хяналтын зөвлөлөөс хүргүүлсэн санал, дүгнэлтийг СЗХ үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

6. Бусад асуудлын талаар

- Хяналтын зөвлөлийн гишүүдийн санаачлагаар бичил санхүү, даатгал, үнэт цаасны харилцааг зохицуулж буй эрх зүйн акт, журам, зааврыг боловсронгуй болгох чиглэлээр зарим тодорхой дүгнэлт саналыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, СЗХ-нд хүргүүлсэн.
- СЗХ-ноос гаргасан шийдвэртэй холбоотой нийтлэг маргаан үүсч байгаа шалтгааныг судлан асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулж, үйл ажилланаандаа хэрэгжүүлж байна.
- СЗХ-ны 2013 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан болон уг аудитын дүгнэлтийн мөрөөр гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцсан.
- СЗХ-ноос зохион байгуулсан “Хорооны 2013 оны стратегийн хэлэлцүүлэг болон орон нутгийн төлөөлөгчид”-ийн семинар, Санхүүгийн салбарын Хяналт зохицуулалтын байгууллага үүсч хөгжсөний 20 жилийн ой”, “СЗХ-ны зохицуулалтын байгууллагуудын үндэсний чуулга уулзалт-2014 он” зэрэг арга хэмжээнд Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо.

- УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2014 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 14-р тогтоолоор байгуулагдсан “СЗХ-ноос гаргасан шийдвэртэй холбогдуулан иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийн байдал, УИХ болон Эдийн засгийн байнгын хорооноос тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн биелэлт болон Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудын хэрэгжилтийг шалгах, СЗХ-ны 2013 оны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт оролцож ажилласан.
- Монголын даатгагчдын холбооноос тавьсан хүсэлтийн дагуу “Монгол Улсад арилжааны даатгалын тогтолцоо үүсч хөгжсөн түүхэн замнал (1934-2014)” номыг хэвлүүлсэн.

7. Санал

Ажлын төлөвлөгөөнд даатгал, үнэт цаас, бичил санхүүгийн харилцааг зохицуулж буй эрх зүйн актыг боловсронгуй болгох шаардлага бий эсэхийг судлах, энэ чиглэлээр санал боловсруулах тухай тусгагдсаны дагуу зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр зарим санал зөвлөмж боловсруулж, нэгтгэн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд энд цөөн зүйлийг товчлон дурьдая.

Манай улсад санхүүгийн зах зээлийн олон тулгуурт бүтэц, тогтолцоо бүрэлдэж чадаагүйгээс банкнаас бусад санхүүгийн салбарын банкны салбартай өрсөлдөх чадвар хязгаарлагдмал байна. Санхүүгийн зах зээлийн энэхүү өрөөсгөл бүтцийг өөрчлөх зорилгоор санхүүгийн бусад салбарыг өрсөлдөх чадвартай болгох, эдийн засгийн банкны зээлээс хамааралтай байдлыг бууруулах, санхүүгийн хямд эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжийг бий болгохыг дэмжиж олон тулгуурт санхүүгийн зах зээлийн шинэ тогтолцоог бий болгохыг төрөөс дэмжих нь нэн чухал юм.

Санхүүгийн зах зээлийн талаар

- Санхүүгийн зах зээлийн хөгжлийн хандлага, эдийн засаг, санхүүгийн гадаад, дотоод орчны байдал, санхүүгийн зах зээлд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан макро эдийн засгийн бодлогын уялдаа холбоог хангах, эрсдэлийг хэмжих, үнэлэх цогц судалгаа, шинжилгээний үндсэн дээр эрсдэлд суурилсан зохицуулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Судалгааны ажлыг эрчимжүүлж шинэ шатанд гаргах, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач шинжээчдийн хүч бололцоонд тулгуурлан суурь судалгаанууд хийх, эдгээрийн үр дүнг зохицуулалтын зорилгоор болон зах зээл сонирхогч, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд ашиглаж хэвшүүлэх;
- Санхүүгийн зохистой харьцааны шаардлагыг тавьж байх, эрсдэлийн төрөл тус бүрт тухайн байгууллагын болон системийн түвшинд оновчтой

зохицуулалтын зохистой харьцааны үзүүлэлт шаардлагыг мөрдүүлэх талаар бие даасан зарчмуудыг бий болгох.

Үнэт цаасны зах зээлийн талаар

- Судалгааны дүнгээс харахад сүүлийн үед үнэт цаасны зах зээлийн нэр хүндийн буурах хандлагатай, хөрөнгийн зах зээлд ихэнх компанийн хувьцааны хэт төвлөрөл явагдаж, тэдгээрийн хувьцаа цөөн хэдэн хүний гарт төвлөрч, зохицуулалтын орчин нь ногдол ашиг тараах хувьцаат компани ил тод байх, бодит, үнэн зөв санхүүгийн тайлангийн мэдээллийг хүргэх боломжийг хааж байгаа зэрэг шалтгаан хөрөнгийн зах зээл хөгжих, сул чөлөөтэй хөрөнгийг дайчлахад хөрөнгө оруулагчдыг татан оролцуулахад сөргөөр байгааг анхааран үзэх;
- Өмнө хуримтлагдсан зарим асуудал, тухайлбал “Зоос банк” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдээс удаа дараа тавьж байгаа шаардлага, хүсэлтийг хэт сунжруулахгүйгээр шийдвэрлэх.

Бичил санхүүгийн талаар

- Банк, ББСБ, ХЗХ-ноос гадуур гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүд зээл нэрээр мөнгө хүүлэх үйл ажиллагаа явуулах хандлага мэдрэгдэж байгааг зохицуулах алхам хийх;

Даатгалын зах зээлийн талаар

- Даатгалын зах зээлийн хөгжлийн хандлага ойрын ирээдүйд компаниуд нэгдэх үйл явц нэмэгдэх, өмнө нь даатгал тэр бүр хүртээлгүй мэт байсан онцлог мэргэжил, салбаруудад зориулагдсан бүтээгдэхүүн үйлчилгээ бий болох, даатгуулах болон даатгалын нөхөн төлбөр олгох үйл явц цахим хэлбэрт бүрэн шилжсэнээр даатгуулагчдын цаг хугацааг хэмнэх боломж бүрдэх, хувь хүн, хуулийн этгээдийн заавал хамрагдах даатгалын хэлбэрүүд шинээр бий болох төлөвийг харуулж байна.
- Орон нутагт даатгалын хуулийн хэрэгжилт хангалтгүй, СЗХ хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх сул байгааг анхаарах шаардлага байна.
- Даатгалын андерратинг хийх нөхцөл шаардлагыг боловсруулж мөрдүүлэх, андеррайтингийн сургалтууд зохион байгуулах, Даатгалын мэргэжлийн актуарч бэлдэхэд онцгойлон анхаарах, Эрсдэлийн үнэлгээнд суурилсан даатгалын хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхэд анхаарах шаардлагатай гэж үзнэ.

Нийтлэг зүйл

- СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа тус байгууллагыг улсын төсвөөс бүрэн санхүүждэг тогтолцоонд шилжүүлэх.